



**“НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 04 сарын 16 өдөр

Дугаар А/11

Улаанбаатар хот

**Хөрөнгө бүртгэх тухай**

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/361 дүгээр захирамж, Налайхын үйлдвэрлэл, технологийн парк ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.14 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газраас балансаас баланст шилжүүлсэн 64.000.000 (жаран дөрвөн сая) төгрөгийн өртөг бүхий Suzuki Vitara маркийн суудлын автомашиныг байгууллагын хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Хөрөнгө бүртгэлд авсан шийдвэрийн хуулбарыг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт хүргүүлэхийг Ахлах нягтлан бодогч (Г.Ганцэцэг)-д даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ч.РАДНААБАЗАР